

ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2023/111/НА-СТА-ТШЗ

ТӨВ АЙМГИЙН БАЯН СУМЫН ХҮҮХДИЙН ЦЭЦЭРЛЭГИЙН 2022
ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН
АУДИТЫН ТАЙЛАН

Зуунмод хот 2023 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn

Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Ихмонгол хөлөг Аудит ХХК

Утас: 70001778 Цахим хаяг: info@imkaudit.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: www.audit.mn

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	8
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	10
2.6 Аудит хийсэн улсын төсвийн гүйцэтгэлийн тайлан	13
2.8 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	15
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	16
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	16
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	16
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	18
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд	18
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	19
4. АУДИТЫН ТАЙЛАН	21
4.1 Ерөнхий зүйл	21
4.2 Материаллаг байдал.....	21
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт.....	21
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	21
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	23
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	23
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	24
5.1 Төлбөрийн акт	24
5.2 Зөвлөмж.....	24
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	26

Товчилсон үгийн жагсаалт

МУ	Монгол Улс
МУЕА	Монгол улсын ерөнхий аудитор
ЗГ	Засгийн газар
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
УСНБНЗСТОУБ	Улсын Секторын байгууллагуудын нийтлэг зорилготой санхүүгийн тайлагналын онолын үзэл баримтлал
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
БШУС	Боловсрол шинжлэх ухааны сайд
БШУГ	Боловсрол шинжлэх ухааны газар
ТШЗ	Төсвийн шууд захирагч
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг
АШБ	Анхан шатны баримт
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
НХМ	Нэг хэвийн маягт



**ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

41100, Төв аймаг, Зуунмод сум
Утас: 70272582, Цахим шуудан: tuv@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

2023.02.24 № 01/173
танай _____ -ны № _____ -т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төв аймгийн Баян сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Төв аймгийн Баян сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн дараах залруулагдаагүй алдаа, зөрчил тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан нь дангаараа буюу эсвэл нийтээрээ санхүүгийн тайланд материаллаг боловч өргөн тархаагүй, санхүүгийн тайлангийн эрх ба үүрэг, тохиолдсон байх, үнэн зөв байх, иж бүрэн байх мэдэгдлүүдийг хангахгүй байна. Үүнд:

- Цэцэрлэгийн хүүхдийн хоол хүнсний материалаас хэмнэгдсэн 2,086.9 мянган төгрөгийн үлдэгдлийг төрийн сангийн нэгдсэн дансанд төвлөрүүлээгүй. байна.
- Цалингийн дэлгэрэнгүй тооцооны цалингийн зөрүү хэсэгт анхан шатны баримтгүйгээр 11,273.0 мянган төгрөгийн залруулга хийгдсэн байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Төв аймгийн Баян сумын хүүхдийн цэцэрлэгийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг өмнөх онтой харьцуулахад мөнгөн хөрөнгийн дансанд их хэмжээний өөрчлөлт орсон байна. Энэ нь Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 91 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан "Хувьсах зардлын дундаж нормативаар төсөв хуваарилах, санхүүжүүлэх журам"-ын 8.7 дахь заалтад төсвийн жилийн эцэст зарцуулагдаагүй үлдсэн мөнгөн хөрөнгийг улсын төсөвт татан төвлөрүүлэлгүйгээр дараагийн төсвийн жилд шилжүүлэн зарцуулахаар заасантай холбоотой мөнгөн хөрөнгийн данс 76,361.8 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Аудитын гол асуудал

Тайлант онд 2022 онд боловсролын байгууллагыг үйл ажиллагааны үр дүн, чанар, гүйцэтгэл, сургалтын хөтөлбөрийн бодит өртөгт суурилсан хувьсах зардлаар санхүүжүүлэх,

19020365

цалин хөлсний бодлого хэрэгжүүлэхэд чиглэсэн холбогдох эрх зүйн актуудыг шинэчлэн баталж, мөрдүүлсэн асуудлыг аудитын гол асуудал гэж үзлээ.

Бусад асуудлын хэсэг

Төв аймгийн Баян сумын хүүхдийн цэцэрлэг "Хүүхдийн нийгэм, сэтгэл зүй, танин мэдэхүйн хөгжлийг дэмжих, боловсрол эзэмшихэд тулгарч буй бэрхшээлийг арилгаж сурах тэгш боломж бүрдүүлэх, хувь хүний онцлогт нийцүүлэн сургалт, үйл ажиллагааг чанар, үр дүнтэй зохион байгуулах, хамтран суралцах арга барилыг сургалтад нэвтрүүлэх." гэсэн зорилго дэвшүүлэн ажилласан байна.

Цэцэрлэгийн эрхлэгч нь Төв аймгийн Баян сумын Засаг даргаар батлуулсан гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 4 зорилтын хүрээнд 78 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 96.6 хувьтай дүгнэсэн байна

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагагүй гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	31,666,436.00	109,081,207.68
31	МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ	-	76,361,829.68
312	Банканд байгаа бэлэн мөнгө	-	76,361,829.68
3121	Төгрөг	-	76,361,829.68
31211	Төрийн сангийн харилцах	-	76,361,829.68
35	БАРАА МАТЕРИАЛ	31,666,436.00	32,719,378.00
351	Түүхий эд материал	2,894,800.00	2,894,800.00
35110	Тусгай зориулалттай материал	2,759,800.00	2,759,800.00
35130	Эм боох материал	135,000.00	135,000.00
354	Хангамжийн материал	28,771,636.00	29,824,578.00
35410	Бичиг хэргийн материал	1,426,710.00	1,315,632.00
35420	Аж ахуйн материал	13,987,020.00	14,622,020.00
35460	Хүнсний материал	2,947,330.00	2,086,900.00
35470	Бусад хангамжийн материал	10,410,576.00	11,800,026.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	397,316,288.34	1,306,155,652.41
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	397,316,288.34	1,306,155,652.41
392	Биет хөрөнгө	389,157,288.06	1,298,037,902.10
39201	Барилга, байгууламж	389,554,200.00	1,289,554,200.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(50,152,706.70)	(57,187,022.55)
39205	Машин, тоног төхөөрөмж	70,417,081.00	76,150,810.20
39206	Хуримтлагдсан элэгдэл	(50,970,259.20)	(47,420,017.13)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	29,864,019.00	36,810,025.40
39208	Хуримтлагдсан элэгдэл	(20,758,496.03)	(18,862,243.81)
39214	Бусад үндсэн хөрөнгө	27,434,000.00	27,209,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(6,235,550.01)	(8,221,850.01)
39217	Номын фонд	5,000.00	5,000.00
393	Биет бус хөрөнгө	8,159,000.28	8,117,750.31
39301	Программ хангамж	550,000.00	550,000.00
39302	Хасагдуулаг	(384,999.72)	(426,249.69)
39303	Бусад биет бус хөрөнгө	7,994,000.00	7,994,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	428,982,724.34	1,415,236,860.09
4	НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	-	-
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	-
413	Өглөг	-	-
41310	Ажиллагчидтай холбогдсон өглөг	-	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	428,982,724.34	1,415,236,860.09
51	Засгийн газрын хувь оролцоо	428,982,724.34	1,415,236,860.09
511	Засгийн газрын оруулсан капитал /ЗГСан/ орон нутгийн сан	52,913,084.00	52,913,084.00
51101	Өмч: -Төрийн өмч	52,913,084.00	52,913,084.00
512	Хуримтлагдсан үр дүн	342,828,767.74	1,329,082,903.49
51210	Өмнөх үеийн үр дүн	342,828,767.74	(86,389,956.60)
51220	Тайлант үеийн үр дүн	-	1,415,472,860.09
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	33,240,872.60	33,240,872.60
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	428,982,724.34	1,415,236,860.09

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	213,121,850.00	1,675,674,479.94
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	221,650.00	1,355,161,279.94
120	Нийтлэг татварын бус орлого	221,650.00	1,355,161,279.94
120017	Үнэ төлбөргүй хүлээж авсан Үндсэн хөрөнгө	-	1,323,275,393.94
120018	Үнэ төлбөргүй хүлээж авсан Бараа материал	221,650.00	31,885,886.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	20,719,400.00	52,463,200.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	192,180,800.00	268,050,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	19,217,700.00
131104	Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид	-	19,217,700.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	20,719,400.00	33,245,500.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	20,719,400.00	33,245,500.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)	230,356,376.50	260,201,619.85
21	УРСГАЛ ЗАРДАЛ	230,356,376.50	260,201,619.85
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	197,106,713.95	239,372,603.80
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	127,864,737.80	141,532,434.74
210101	Цалин	118,541,403.30	126,748,125.69
210102	Нэмэгдэл цалин	1,092,259.41	10,960,429.55
210104	Урамшуулал	8,231,075.09	3,823,879.50
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	17,889,290.65	18,509,047.53
210201	Тэтгэврийн даатгалын шимтгэл	12,680,759.46	12,831,682.09
210202	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	1,373,347.24	1,500,568.23
210203	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	1,024,757.81	1,129,894.54
210204	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	248,531.76	268,695.38
210205	Эрүүл мэндийн даатгалын хураамж	2,561,894.38	2,778,207.29
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	18,710,009.00	20,421,252.00
210301	Гэрэл цахилгааны зардал	2,776,923.00	3,592,116.00
210302	Түлш, халаалтын зардал	15,730,736.00	15,730,736.00
210303	Цэвэр, бохир усны зардал	202,350.00	1,098,400.00
2104	Хангамж, бараа материалын зардал	1,925,250.00	388,078.00
210401	Бичиг хэргийн материал	79,500.00	388,078.00
210402	Тээвэр, шатахууны зардал	196,650.00	-
210403	Шуудан холбоо интернэтийн төлбөр	200,000.00	-
210405	Хог хаягдал устгах, цэвэрлэх	418,100.00	-
210406	Бага үнэ түргэн элэгдэл зүйлс	1,031,000.00	-
2105	Нормативт зардал	6,085,600.00	32,713,000.00
210501	Эм	90,000.00	-
210502	Хоол	5,995,600.00	32,713,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	462,000.00	500,000.00
210604	Урсгал засвар	462,000.00	500,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж	-	330,000.00

210806	Мэдээллийн технологийн үйлчилгээний хөлс	-	330,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	24,169,826.50	24,978,791.53
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,030,000.00	4,974,550.00
210902	Хичээл сургалт, үйлдвэрлэлийн дадлагын зардал	610,500.00	2,884,500.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	22,529,326.50	17,119,741.53
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	33,249,662.55	20,829,016.05
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	19,114,200.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	9,208,000.00
213208	Хөдөө ОН-т тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	-	9,906,200.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	31,736,921.55	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	31,736,921.55	-
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	1,512,741.00	1,714,816.05
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,512,741.00	1,714,816.05
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III=I-II)	(17,234,526.50)	1,415,472,860.09
5	НИЙТ ҮР ДҮН (VII=III+VI)	(17,234,526.50)	1,415,472,860.09

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

Дансны код	Үзүүлэлт	/төгрөгөөр/	
		Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	212,900,200.00	320,513,200.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	212,900,200.00	320,513,200.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	192,180,800.00	268,050,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	19,217,700.00
131104	Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захи	-	19,217,700.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	20,719,400.00	33,245,500.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	20,719,400.00	33,245,500.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (II)	212,900,200.00	244,151,370.32
21	УРСГАЛ ЗАРДАЛ	212,900,200.00	244,151,370.32
210	БАРАА АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	179,650,537.45	223,322,354.27
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	127,864,737.80	141,768,434.74
210101	Үндсэн цалин	118,541,403.30	126,984,125.69
210102	Нэмэгдэл	1,092,259.41	10,960,429.55
210104	Үр дүнгийн урамшуулал	8,231,075.09	3,823,879.50
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	17,889,290.65	18,509,047.53
210201	Тэтгэврийн даатгалын шимтгэл	12,617,759.53	12,831,682.09
210202	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	1,398,547.24	1,500,568.23
210203	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	1,034,837.84	1,129,894.54
210204	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	251,051.78	268,695.38
210205	Эрүүл мэндийн даатгалын хураамж	2,587,094.26	2,778,207.29
2103	Байр ашиглалтай холбоотой тогтмол зардал	18,706,659.00	20,219,852.00
210301	Гэрэл цахилгааны зардал	2,776,923.00	3,592,116.00
210302	Түлш, халаалтын зардал	15,730,736.00	15,730,736.00
210303	Цэвэр, бохир усны зардал	199,000.00	897,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	3,030,800.00	103,500.00
210401	Бичиг хэрэг	100,000.00	103,500.00
210402	Тээвэр, шатахуун	200,000.00	-
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	200,000.00	-
210404	Ном, хэвлэл	650,000.00	-
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	294,000.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,586,800.00	-
2105	Нормативт зардал	10,018,550.00	31,852,570.00
210501	Эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	45,000.00	-
210502	Хоол, хүнс	8,473,750.00	31,852,570.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,499,800.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	500,000.00	500,000.00
210604	Урсгал засвар	500,000.00	500,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	-	360,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	360,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,640,500.00	10,008,950.00

210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,030,000.00	7,758,950.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	610,500.00	2,250,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	33,249,662.55	20,829,016.05
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	19,114,200.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	9,208,000.00
213208	Хөдөө орон нутагт тогтвортой ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	-	9,906,200.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	31,736,921.55	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	31,736,921.55	-
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	1,512,741.00	1,714,816.05
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,512,741.00	1,714,816.05
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	-	76,361,829.68
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	76,361,829.68
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	76,361,829.68

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

КОД	ҮЗҮҮЛЭЛТ	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
	ДАНС	511	51300	51210+51220	
C01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	52,913,084.00	33,240,872.60	360,063,294.24	446,217,250.84
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	52,913,084.00	33,240,872.60	360,063,294.24	446,217,250.84
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	(17,234,526.50)	(17,234,526.50)
C08	2021 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	52,913,084.00	33,240,872.60	342,828,767.74	428,982,724.34
D01	2022 оны 01-р сарын 31-ээрх үлдэгдэл	52,913,084.00	33,240,872.60	342,828,767.74	428,982,724.34
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	(429,218,724.34)	(429,218,724.34)
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	52,913,084.00	33,240,872.60	(86,389,956.60)	(236,000.00)
D08	Тайлант үеийн үр дүн /Цэвэр ашиг алдагдал/	-	-	1,415,472,860.09	1,415,472,860.09
D09	2022 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	52,913,084.00	33,240,872.60	1,329,082,903.49	1,415,236,860.09

2.5 Аудит хийсэн нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-	-	-
I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	301,725,200.00	242,436,554.27	(59,288,645.73)	80.4
УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	301,725,200.00	242,436,554.27	(59,288,645.73)	80.4
Бараа, үйлчилгээний зардал	301,725,200.00	223,322,354.27	(78,402,845.73)	74.0
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	211,041,000.00	141,768,434.74	(69,272,565.26)	67.2
Үндсэн цалин	166,391,700.00	126,984,125.69	(39,407,574.31)	76.3
Нэмэгдэл	41,914,200.00	10,960,429.55	(30,953,770.45)	26.1
Унаа, болон бусад нөхөн олговор	498,000.00	-	(498,000.00)	-
Урамшуулал	2,237,100.00	3,823,879.50	1,586,779.50	170.9
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	26,380,200.00	18,509,047.53	(7,871,152.47)	70.2
Тэтгэврийн даатгал	17,938,500.00	12,831,682.09	(5,106,817.91)	71.5
Тэтгэмжийн даатгал	2,110,500.00	1,500,568.23	(609,931.77)	71.1
ҮОМШӨ ний даатгал	1,688,300.00	1,129,894.54	(558,405.46)	66.9
Ажилгүйдлийн даатгал	422,000.00	268,695.38	(153,304.62)	63.7
Эрүүл мэндийн даатгал	4,220,900.00	2,778,207.29	(1,442,692.71)	65.8
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	20,232,700.00	20,219,852.00	(12,848.00)	99.9
Гэрэл цахилгаан	3,962,000.00	3,592,116.00	(369,884.00)	90.7
Түлш, халаалт	15,730,700.00	15,730,736.00	36.00	100.0
Цэвэр, бохир ус	540,000.00	897,000.00	357,000.00	166.1
Хангамж, бараа материалын зардал	-	103,500.00	103,500.00	-
Бичиг хэрэг	-	103,500.00	103,500.00	-
Нормативт зардал	31,855,300.00	31,852,570.00	(2,730.00)	100.0
Хоол, хүнс	31,855,300.00	31,852,570.00	(2,730.00)	100.0
Эд хогшил худалдан авах	500,000.00	500,000.00	-	100.0
Урсгал засвар	500,000.00	500,000.00	-	100.0
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	814,000.00	360,000.00	(454,000.00)	44.2
Мэдээллийн технологийн зардал	814,000.00	360,000.00	(454,000.00)	44.2
Бараа үйлчилгээний бусад зардал	10,902,000.00	10,008,950.00	(893,050.00)	91.8
Бараа үйлчилгээний бусад зардал	8,652,000.00	7,758,950.00	(893,050.00)	89.7
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,250,000.00	2,250,000.00	-	100.0
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	19,114,200.00	19,114,200.00	-
Бусад урсгал шилжүүлэг	-	19,114,200.00	19,114,200.00	-
Тэтгэвэрт гарахад нь олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	9,208,000.00	9,208,000.00	-
Хөдөө ОН-т тогтвор суурьшилтай ажилласны тэтгэмж	-	9,906,200.00	9,906,200.00	-
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	301,723,400.00	320,513,200.00	18,789,800.00	106.2
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	268,050,000.00	268,050,000.00	-	100.0
Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	268,050,000.00	268,050,000.00	-	100.0

ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	33,673,400.00	33,245,500.00	(427,900.00)	98.7
Орон нутгийн төсвөөс	33,673,400.00	33,245,500.00	(427,900.00)	98.7
Нэмэлт санхүүжилтийн орлого	-	19,217,700.00	19,217,700.00	-
Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	19,217,700.00	19,217,700.00	-
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-	-	-
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	76,361,829.68	76,361,829.68	-
ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	-	-	-	-
БАЙГУУЛЛАГЫН ТОО	-	-	-	-
АЖИЛЛАГСДЫН ТОО	13	13	-	100.0
Удирдах ажилтан	1	1	-	100.0
Гүйцэтгэх ажилтан	6	6	-	100.0
Үйлчлэх ажилтан	6	6	-	100.0
СУРАЛЦАГЧДЫН ТОО /жилийн дунджаар/	175	175	-	100.0

2.6 Аудит хийсэн улсын төсвийн гүйцэтгэлийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-	-	-
I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	268,051,800.00	191,688,170.32	(76,363,629.68)	71.5
УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	268,051,800.00	191,688,170.32	(76,363,629.68)	71.5
Бараа, үйлчилгээний зардал	268,051,800.00	191,688,170.32	(76,363,629.68)	71.5
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	199,538,200.00	132,158,806.37	(67,379,393.63)	66.2
Үндсэн цалин	156,425,300.00	117,634,486.32	(38,790,813.68)	75.2
Нэмэгдэл	40,875,800.00	10,700,440.55	(30,175,359.45)	26.2
Урамшуулал	2,237,100.00	3,823,879.50	1,586,779.50	170.9
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	24,942,300.00	17,307,843.95	(7,634,456.05)	69.4
Тэтгэврийн даатгал	16,960,700.00	12,014,863.66	(4,945,836.34)	70.8
Тэтгэмжийн даатгал	1,995,400.00	1,404,471.93	(590,928.07)	70.4
ҮОМШӨ ний даатгал	1,596,300.00	1,053,017.49	(543,282.51)	66.0
Ажилгүйдлийн даатгал	399,100.00	249,476.15	(149,623.85)	62.5
Эрүүл мэндийн даатгал	3,990,800.00	2,586,014.72	(1,404,785.28)	64.8
Нормативт зардал	31,855,300.00	31,852,570.00	(2,730.00)	100.0
Хоол, хүнс	31,855,300.00	31,852,570.00	(2,730.00)	100.0
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	814,000.00	360,000.00	(454,000.00)	44.2
Мэдээллийн технологийн зардал	814,000.00	360,000.00	(454,000.00)	44.2
Бараа үйлчилгээний бусад зардал	10,902,000.00	10,008,950.00	(893,050.00)	91.8
Бараа үйлчилгээний бусад зардал	8,652,000.00	7,758,950.00	(893,050.00)	89.7
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,250,000.00	2,250,000.00	-	100.0
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	268,050,000.00	268,050,000.00	-	100.0
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	268,050,000.00	268,050,000.00	-	100.0
Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	268,050,000.00	268,050,000.00	-	100.0
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-	-	-
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	76,361,829.68	76,361,829.68	-
ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	-	-	-	-
БАЙГУУЛЛАГЫН ТОО	-	-	-	-
АЖИЛЛАГСДЫН ТОО	13	13	-	100.0
Удирдах ажилтан	1	1	-	100.0
Гүйцэтгэх ажилтан	6	6	-	100.0
Үйлчлэх ажилтан	6	6	-	100.0
СУРАЛЦАГЧДЫН ТОО /жилийн дунджаар/	175	175	-	100.0

2.7 Аудит хийсэн орон нутгийн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-	-	-
I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	33,673,400.00	31,530,683.95	(2,142,716.05)	93.6
УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	33,673,400.00	31,530,683.95	(2,142,716.05)	93.6
Бараа, үйлчилгээний зардал	33,673,400.00	31,530,683.95	(2,142,716.05)	93.6
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	11,502,800.00	9,609,628.37	(1,893,171.63)	83.5
Үндсэн цалин	9,966,400.00	9,349,639.37	(616,760.63)	93.8
Нэмэгдэл	1,038,400.00	259,989.00	(778,411.00)	25.0
Унаа, болон бусад нөхөн олговор	498,000.00	-	(498,000.00)	-
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,437,900.00	1,201,203.58	(236,696.42)	83.5
Тэтгэврийн даатгал	977,800.00	816,818.43	(160,981.57)	83.5
Тэтгэмжийн даатгал	115,100.00	96,096.30	(19,003.70)	83.5
ҮОМШӨ ний даатгал	92,000.00	76,877.05	(15,122.95)	83.6
Ажилгүйдлийн даатгал	22,900.00	19,219.23	(3,680.77)	83.9
Эрүүл мэндийн даатгал	230,100.00	192,192.57	(37,907.43)	83.5
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	20,232,700.00	20,219,852.00	(12,848.00)	99.9
Гэрэл цахилгаан	3,962,000.00	3,592,116.00	(369,884.00)	90.7
Түлш, халаалт	15,730,700.00	15,730,736.00	36.00	100.0
Цэвэр, бохир ус	540,000.00	897,000.00	357,000.00	166.1
Эд хогшил худалдан авах	500,000.00	500,000.00	-	100.0
Урсгал засвар	500,000.00	500,000.00	-	100.0
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	33,673,400.00	33,245,500.00	(427,900.00)	98.7
ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	33,673,400.00	33,245,500.00	(427,900.00)	98.7
Орон нутгийн төсвөөс	33,673,400.00	33,245,500.00	(427,900.00)	98.7
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-	-	-
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-	-	-
ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	-	-	-	-
БАЙГУУЛЛАГЫН ТОО	-	-	-	-
АЖИЛЛАГСДЫН ТОО	13	13	-	100.0
Удирдах ажилтан	1	1	-	100.0
Гүйцэтгэх ажилтан	6	6	-	100.0
Үйлчлэх ажилтан	6	6	-	100.0
СУРАЛЦАГЧДЫН ТОО /жилийн дунджаар/	175	175	-	100.0

2.8 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	-	19,217,700.00
УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	-	19,217,700.00
Бараа, үйлчилгээний зардал	-	103,500.00
Хангамж, бараа материалын зардал	-	103,500.00
Бичиг хэрэг	-	103,500.00
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	19,114,200.00
Бусад урсгал шилжүүлэг	-	19,114,200.00
Тэтгэвэрт гарахад нь олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	9,208,000.00
Хөдөө ОН-т тогтвор суурьшилтай ажилласны тэтгэмж	-	9,906,200.00
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	19,217,700.00
Нэмэлт санхүүжилтийн орлого	-	19,217,700.00
Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	19,217,700.00
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-
ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	-	-
БАЙГУУЛЛАГЫН ТОО	-	-
АЖИЛЛАГСДЫН ТОО	13	13
Удирдах ажилтан	1	1
Гүйцэтгэх ажилтан	6	6
Үйлчлэх ажилтан	6	6

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Байгууллагын үйл ажиллагааны чиглэл, зорилго, зорилтын талаар

Төв аймгийн Баян сумын Хүүхдийн цэцэрлэг нь 2022-2023 оны хичээлийн жилд “Хүүхдийн нийгэм, сэтгэл зүй, танин мэдэхүйн хөгжлийг дэмжих, боловсрол эзэмшихэд тэгш боломж бүрдүүлэх, сурагчдын сонирхолд тулгуурлан сургалт, үйл ажиллагааны чанар, үр дүнтэй зохион байгуулах, хамтран суралцах арга барилыг эзэмшүүлэх” зорилтуудыг дэвшүүлэн ажилласан байна.

Монгол Улсын Бага, дунд боловсролын тухай хуульд бага, суурь, бүрэн дунд боловсролын зорилгыг:

- Бага боловсрол: Эх хэлний суурь чадамжтай, бүтээлч, сурах арга барилтай Монгол хүүхэд төлөвшүүлэх;
- Суурь боловсрол: Амьдрах ухаан, шинжлэх ухааны суурь мэдлэг, чадвар эзэмшсэн, бие даан бүтээлчээр суралцах чадамжтай иргэн төлөвшүүлэх;
- Бүрэн дунд боловсролын зорилго нь мэдээлэл боловсруулах, шийдвэр гаргах, суралцах чадвар бүхий ирээдүйд эзэмших мэргэжлийн ерөнхий суурь чадамжтай иргэн төлөвшүүлэх гэж тодорхойлсон.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар:

Төв аймгийн Баян сумын Хүүхдийн цэцэрлэг нь мэдээлэл боловсруулах, шийдвэр гаргах, суралцах чадвар бүхий ирээдүйд эзэмших мэргэжлийн ерөнхий суурь чадамжтай иргэн төлөвшүүлэх үйл ажиллагаа явуулдаг Боловсрол, шинжлэх ухааны яамны харьяа байгууллага юм.

Тайлант онд боловсролын салбарт шинэчлэл хийж, түүнийг дэмжсэн төсвийг батлан хэрэгжүүлэхийг зорьсон байна. Боловсролын тухай хууль, Сургуулийн өмнөх боловсролын тухай хуулийг 2021 онд өөрчлөн найруулснаар гүйцэтгэл, үр дүнд суурилсан санхүүжилтийн тогтолцоог бий болгож “хувьсах зардал”-ыг улсын төсвөөс санхүүжүүлэх болсон байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна.

1. Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулга 2022 оны 01 дүгээр сарын 01-ээс хэрэгжиж эхэлсэн.
2. Төрийн бүх шатны байгууллага, нийтийн алба, тэдгээрийн үйл ажиллагаанд санхүүгийн сахилга батыг мөрдүүлж, ил тод байдлыг хангах, үр ашгийг нэмэгдүүлэх, үрэлгэн байдлыг хязгаарлах хяналт тавихад чиглэсэн “Төрийн хэмнэлтийн тухай” хууль /2022 оны 4 дүгээр сарын 02-ны өдөр батлагдсан./
3. Төрийн үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн цалингийн доод хэмжээг Засгийн газрын 2022 оны 107 дугаар тогтоолоор тогтоосон ба 2022 оны 192 дугаар тогтоолоор эрүүл мэндийн салбараас бусад төрийн үйлчилгээний байгууллага болон төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад туслах албан тушаалын цалингийн доод хэмжээг өөрчлөн тогтоосон байна.
4. Боловсролын салбарт хийж байгаа шинэчлэл, үйл ажиллагаа, төсөв санхүүг дэмжсэн шийдвэрийг Засгийн газар, салбарын яамнаас гаргаж мөрдүүлсэн байна. Тухайлбал:
 - Засгийн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн 403 дугаар тогтоолоор Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Боловсролын ерөнхий газрыг байгуулсан ба 2022 оны 131 дүгээр тогтоолоор Боловсролын ерөнхий газрын даргыг Сургуулийн өмнөх болон бага, дунд боловсролын, мэргэжлийн боловсролын, техникийн боловсролын сургалтын байгууллагын төсвийн төвлөрүүлэн захирагчаар баталсан байна.
 - Засгийн газрын 2022 оны 91 дүгээр тогтоолоор “Сургуулийн өмнөх боловсрол эзэмшүүлэхэд нэг суралцагчдад хувьсах зардлын дундаж норматив, түүний бүрэлдэхүүн”, “Төрийн болон орон нутгийн өмчит цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн нэг суралцагчид ногдох хувьсах зардлын байршил, хэв шинж, хүүхдийн

тооноос хамаарсан өсөн нэмэгдэх итгэлцүүр", "Хувьсах зардлын дундаж нормативаар төсөв хуваарилах, санхүүжүүлэх аргачлал" баталсан байна.

- Засгийн газрын 2022 оны 252 дугаар тогтоолоор "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ын Дөрөв.Төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын багш, туслах багш, албан хаагчид олгох улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулал" хэсэгт өөрчлөлт оруулан 4.4.2-т ерөнхий боловсролын сургуулийн багшид мөнгөн урамшуулал олгох шалгуур, үзүүлэлтийг тогтоосон.
 - БШУС-ын 2022 оны А/122 дугаар тушаалаар Засгийн газрын 2022 оны 91 дүгээр тогтоолыг үндэслэн төрийн болон орон нутгийн өмчит сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургуулийн үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн зарим албан хаагчийн цалингийн хэмжээг тогтоосон.
 - БШУС-ын 2022 оны А/170 дүгээр тушаалаар "төрийн болон орон нутгийн өмчийн ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн хичээл сургалтын үйл ажиллагааны зардлыг төлөвлөх хуваарилах заавар"-ыг 1 дүгээр, "багшийн тасралтгүй хөгжлийг дэмжих, үйл ажиллагааны санхүүжилт, түүнийг зарцуулах заавар"-ыг 2 дугаар, "цахим хэрэглээний зардлыг төлөвлөх, хуваарилах заавар"-ыг 3 дугаар, "тоног төхөөрөмжийн нөхөн хангалтын зардлыг төлөвлөх хуваарилах, санхүүжүүлэх зааврыг 4 дүгээр хавсралтаар тус тус баталсан байна.
 - БШУС-ын 2022 оны А/259 дүгээр тушаалаар "Цэцэрлэг, ерөнхий боловсролын багшийг эрүүл мэндийн нэмэлт үзлэг, оношилгоонд хамруулах заавар"-ыг баталсан байна.
 - БШУС-ын 2022 оны А/430 дугаар тушаалаар багшийн ажлыг үнэлэх журмыг шинэчлэн баталсан.
 - БШУС-ын 2022 оны А/452 дугаар тушаал "Хувьсах зардлын тоног төхөөрөмжийн нөхөн хангалтын тухай"
 - БШУС-ын 2022 оны А/500 дугаар тушаалаар төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн үйл ажиллагааны гүйцэтгэлийн чанар, үр дүнг үнэлж, үр дүнгийн нэмэлт урамшууллын зардлыг санхүүжүүлэхэд баримтлах чиглэлийг баталсан.
 - БШУС-ын 2022 оны А/224 дугаар тушаалаар "Сургуулийн өмнөх боловсролын хувилбарт сургалт явуулах журам"-ыг баталсан.
5. Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.7-д "Суутган төлөгч нь албан татвар төлөгчийн энэ хуулийн 21.1-д заасны дагуу ногдох албан татвар, 23.1-д заасны дагуу эдлэх хөнгөлөлтийг жилийн эцсийн тайлангаар эцэслэн тооцож тайлагнан, холбогдох татварыг төсөвт шилжүүлнэ"
 6. Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай Монгол Улсын Загийн газрын 2022 оны 5 дугаар сарын 25-ны өдрийн 203 дугаар тогтоол
 7. "Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль/дотуур байрын хүүхдэд хоол, хүнсний хангамж, үйлчилгээ үзүүлэхэд мөрдөх журам"-ыг батлах тухай Боловсрол шинжлэх ухааны сайдын 2022 оны 02 дугаар сарын 22-ны өдрийн А/59 дүгээр тушаал
 8. Албан томилолтын зардлын тариф шинэчлэн батлах тухай Сангийн 2022 оны 6 дугаар сарын 02-ны өдрийн 120 дугаар тушаал.

Байгууллагын дотоод хяналтын талаар

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод аудитын үйл ажиллагаа нь зөвхөн үндсэн үйл ажиллагаанд чиглэгдэж, нягтлан бодох бүртгэл, төсвийн төлөвлөлт, зарцуулалт, шилэн дансны, төсвийн, төрийн болон орон нутгийн өмчийн, төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах, төрийн хэмнэлтийн тухай зэрэг хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт хийдэггүй, санхүүгийн мэргэжлийн ажилтан дотоод хяналтын ажлын хэсгийн бүрэлдэхүүнд томилогдоогүй, ажилтнууд нь дотоод хяналтын талаар сургалтад хамрагдаагүй, дотоод хяналтын талаар зохих мэдлэг эзэмшээгүй, дотоод хяналтын ажиллах

журамгүй тул дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилтийг үр нөлөөгүй байна гэж үзлээ.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд тусалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймгийн Баян сумын хүүхдийн цэцэрлэгийн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккуруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.4, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан иж бүрдлийн дагуу бэлтгэж толилуулсан байна гэж үзлээ.

Харин төсвийн гүйцэтгэлийн тайланг мөнгөн сууриар бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5-д заасны дагуу иж бүрэн ирүүлсэн.

Байгууллагын мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн талаар

Санхүү нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд мөрдөж буй Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт УСНББОУС, хууль, тогтоол, тушаал, заавруудын өөрчлөлтийг тусгаагүй, байгууллагын удирдлагын тушаал шийдвэрээр батлаагүйгээс НБББББ-ийг өөрийн байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохируулан боловсруулах шаардлага тулгарч байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Төв аймгийн Баян сумын хүүхдийн цэцэрлэгийн 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны 1 дүгээр сараас 4 дүгээр саруудад тогтмол зардал, үйлчилгээний ажилтнуудын цалин, шимтгэлийг орон нутгийн төсвөөс, бусад зардлуудыг улсын төсвөөс санхүүжүүлж ирснийг, 2022 оны 5 дугаар сараас төсвийн хуваарьт өөрчлөлт оруулан цахилгаан эрчим хүч, халаалт, цэвэр бохир ус, урсгал засварын зардлыг орон нутгийн төсвөөс, бусад зардлыг улсын төсвөөс санхүүжүүлсэн байна.

Төв аймгийн Баян сумын хүүхдийн цэцэрлэгийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь Монгол Засгийн газрын 2022 оны 91 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Ерөнхий боловсролын сургууль, сургуулийн өмнөх байгууллагын нэг суралцагчид ногдох хувьсах зардлын дундаж нормативын бүрэлдэхүүн, зардлын зориулалт, арга хэмжээний дэлгэрэнгүй заавар”-д төсвийн зарлагыг эдийн засгийн 2 ангиллаар баталснаас шалтгаалж, Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар баталсан “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”, Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалын 2 дугаар хавсралт, 2014 оны 5 дугаар тушаалын 5 дугаар хавсралтаар баталсан “Балансын дансны жагсаалт”-ын дагуу тайлагнагдаагүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 986,254.2 мянган төгрөгөөр буюу 229,9 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	76,361.8	76,361.8
Бараа материал	31,666.4	32,719.4	1,053.0
Үндсэн хөрөнгө	397,316.3	1,306,155.7	908,839.4
Нийт хөрөнгө	428,982.7	1,415,236.9	986,254.2
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	428,982.7	1,415,236.9	986,254.2
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	428,982.7	1,415,236.9	986,254.2

Дээрх хүснэгтээс харахад мөнгөн хөрөнгө, бараа материал үндсэн хөрөнгө, эздийн өмчийн данс өмнөх оноос нэмэгдсэн үзүүлэлттэй байна. Үүнд:

1. Тайлант онд мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 76,361.8 мянган төгрөгөөр өссөн нь улсын төсвөөс хүлээн авсан санхүүжилтийн зарцуулагдаагүй үлдэгдлийг буцаан төвлөрүүлээгүй нь гол нөлөө үзүүлсэн байна.
2. Бараа материал дансны үлдэгдэл өмнөх оноос 1,053.0 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд 219.5 мянган төгрөгийн бараа материалыг үнэ төлбөргүй, 41,009.0 мянган төгрөгийн бараа материалыг худалдан авч, 40,175.5 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулсан нь гол нөлөө үзүүлсэн байна.
3. Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл өмнөх оноос 908,254.2 мянган төгрөгөөр өссөн нь Баян сумын ЗДТГ-аас 900,000.0 мянган төгрөгийн цэцэрлэгийн шинэ барилга ашиглалтад оруулж, 25,959.1 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга хэрэгслийг үнэ төлбөргүй хүлээн авч бүртгэсэн нь нөлөөлсөн байна.
4. Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 986,254.2 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүн нэмэгдсэнтэй холбоотой байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 474,326.7 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 474,326.7 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас 172,601.5 мянган төгрөгөөр бууруулан 301,725.2 мянган төгрөгөөр төсвийг баталсан байна. Энэ нь Төв аймгийн Баян сумын хүүхдийн цэцэрлэгийн төсвийн захирагч төсвийн төслийг бодитой, үндэслэлтэй боловсруулаагүйгээс шалтгаалсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсвийг 172,601.5 мянган төгрөгөөр бууруулж тодотгосон байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 8 арга хэмжээг санхүүжүүлэхээр 268,050.0 мянган төгрөгийг улсын төсвөөс, 33,673.4 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс, бүрдүүлэхээр байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 268,050.0 мянган, орон нутгийн төсвөөс 33,245.5 мянган төгрөгийн нийт 301,295.5 мянган төгрөгийн санхүүжилт олгосон байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 223,218.9 мянган төгрөг буюу 74.0 хувьтай байгаа нь бараа ажил үйлчилгээний зардлын төсвийг 78,504.5 мянган төгрөгөөр дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/					
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
Улсын төсвийн санхүүжих					
1	81605-Эрүүл мэндийг дэмжих	1,100.0	990.0	(110.0)	90.0
2	81807-Цэцэрлэгийн хүүхдийн хоол	31,855.3	31,852.6	(2.7)	100.0
3	81816-Хүүхдэд ээлтэй сургалтын орчин	1,170.2	1,170.0	(0.2)	100.0
4	81823-Боловсролын байгууллагын багш ажилчдын мэргэжил дээшлүүлэх	1,100.0	320.0	(780.0)	29.1
5	81834-Боловсролын стандарт, сургалтын төлөвлөгөө хөтөлбөрийг хэрэгжүүлэх	208,496.1	135,671.2	(72,824.9)	65.1
6	81835-Сургалтын хэвийн үйл ажиллагаа	24,328.4	21,684.4	(2,644.0)	89.1
Дүн		268,050.0	191,688.2	(76,361.8)	71.5
Орон нутгийн төсвөөс					
1	80111-Төрийн өмчийн тогтмол зардал	20,732.7	20,719.9	(12.8)	99.9
2	80112-Нийтлэг үйлчилгээ	12,940.7	10,810.8	(2,129.9)	83.5
Дүн		33,673.4	31,530.7	(2,142.7)	93.6
НИЙТ ДҮН		301,723.4	223,218.9	(78,504.5)	74.0

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд 19,217.7 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ. Үүнээс: Боловсролын тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1.3, 43.1.7 дугаар заалтын дагуу нийт 2 багшид хөдөө орон нутагт олон жил тогтвор суурьшилтай ажилласны мөнгөн тэтгэмжид 9,906.2 мянган, тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн тэтгэмжийг 1 ажилтанд 9,208.0 мянган, бичиг хэргийн зардал 103.5 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.8-д харуулав..

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тайлант онд Төв аймгийн Баян сумын ерөнхий хүүхдийн цэцэрлэгт төсөл хөтөлбөр хэрэгжээгүй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Төв аймгийн Баян сумын хүүхдийн цэцэрлэгийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулж байхтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Ихмонгол хөлөг Аудит ХХК-ийн ахлах Г.Ариунбат, аудитор Д.Буянравжих, О.Эрдэнэчимэг, шинжээч Б.Ган-Эрдэнэ, Т.Оюун, аудитын менежер Б.Батцэцэг, аудиторын туслах З.Ариунцэцэг, Г.Ариунболд нар гүйцэтгэж, чанарын хяналтыг чанарын хяналтын мэргэжилтэн С.Сождимаа, захирал С.Тунгалаг, Төв аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер О.Амаржаргал, Дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Баян сумын хүүхдийн цэцэрлэгийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Ихмонгол хөлөг Аудит ХХК-д 2023 оны 01 дүгээр сарын 24-ны өдрийн 01 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр батлагдсан төсвийн нийт зардлыг сонгож сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг Төв аймгийн Баян сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2022 оны батлагдсан төсвийн нийт зардал 244,151.4 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 2,441.5 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 1,7091.1 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж, 76,363.6 мянган төгрөгийн хэмнэлт гарган ажилласан нь цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардал 67,379.4 мянган, ажил олгогчоос нийгмийн даатгалын шимтгэлийн зардал 7,634.5 мянган, нормативт зардал 2.7 мянган, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр 454.0 мянган, бараа үйлчилгээний бусад зардал 893.1 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэн байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны цахим хуудсыг шалгахад 158 мэдээлэл байршуулахаас 154 мэдээлэл хугацаанд нь байршуулж, 3 мэдээллийг хугацаа хоцроож, 1 мэдээллийг байршуулаагүй, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 12 удаагийн 217,715.7 мянган төгрөгийн орлогын гүйлгээг 271,793.0 мянган төгрөгөөр буюу 54,077.3 мянган төгрөгөөр илүү байршуулж, 17 удаагийн 233,056.1 мянган төгрөгийн орлого, 13 удаагийн 173,685.9 мянган төгрөгийн зарлагын гүйлгээг шилэн дансны цахим хуудсанд байршуулаагүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5-д "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-т "Энэ хуулийн 3.1-д заасан этгээд Шилэн дансны тухай хуульд заасан мэдээллийг хугацаанд нь байршуулна." гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Дээрх хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах зөвлөмж өгөв.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Төв аймгийн Баян сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 91 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар баталсан "Хүүхдийн цэцэрлэг, сургуулийн өмнөх байгууллагын нэг суралцагчид ногдох хувьсах зардлын дундаж нормативын бүрэлдэхүүн, зардлын зориулалт, арга хэмжээний дэлгэрэнгүй заавар"-д төсвийн зарлагыг эдийн засгийн 2 ангиллаар баталснаас шалтгаалж, Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар баталсан "Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар", Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалын 2 дугаар хавсралт, 2014 оны 5 дугаар тушаалын 5 дугаар хавсралтаар баталсан "Балансын дансны жагсаалт"-ын дагуу тайлагнагдаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн А/95 дугаар тушаалын хавсралт "Албан шаардлага, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-д "Хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг үндэслэн албан шаардлага хүргүүлэв.

Дотоод аудитын үйл ажиллагаа нь зөвхөн сургалтын үндсэн үйл ажиллагаанд чиглэгдсэн, санхүү, шилэн данс, Нягтлан бодох бүртгэлийн, Төсвийн, Төрийн болон орон нутгийн өмчийн, Төрийн хэмнэлтийн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавьдаггүй, дотоод хяналтын ажилтнууд нь зохих мэдлэг эзэмшээгүй, холбогдох сургалтад хамрагдаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.6-д "Дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1-д "Аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн дотоод хяналтын бодлого, удирдлага, зохион байгуулалтыг аж ахуйн нэгж, байгууллагын эрх бүхий этгээд тодорхойлно." гэж заасныг мөрдөөгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Дотоод хяналтын багийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулж, мэргэжил арга зүйгээр хангаж ажиллах зөвлөмж өгөв.

Худалдан авсан хөрөнгө, материалын дүнг, бэлтгэн нийлүүлэгч байгууллагуудын төлбөрийн цахим системд бүртгэсэн дүнтэй тулгахад 2 иргэн, байгууллагын 1,843.6 мянган төгрөгөөр илүү байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д "анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 20 дугаар зүйлийн 20.2.4-д "нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах", Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.6-д "Албан татвар суутган төлөгч төлбөрийн баримтыг өөр дүнгээр олгосон, эсхүл төлбөрийн баримт олгохоос татгалзсан бол албан татвар төлөгч энэ талаар татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад, эсхүл харьяа татварын албанд нэн даруй мэдэгдэх үүрэгтэй." гэж заасантай нийцээгүй, санхүүгийн тайлагналын нийцсэн бөгөөд зохистой байх, иж бүрэн байх гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Дээрх хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллах зөвлөмж өгөв.

Хүүхдийн хоол хүнсний 2,086.9 мянган төгрөгийн материалыг нөөцөлсөн байна. Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.6-д "Нөөцлөх шаардлагатай бараа, материалыг үр ашиггүй удаан хадгалах, шаардлагагүйгээр их хэмжээгээр бараа, материал бэлтгэх, нөөцлөх," гэж заасантай нийцээхгүй, санхүүгийн тайлагналын нийцсэн бөгөөд зохистой байх, иж бүрэн байх гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Дээрх хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллах зөвлөмж өгөв.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Төв аймгийн Баян сумын хүүхдийн цэцэрлэгийн 2022 оны санхүүгийн үйл ажиллагаанд завсрын аудит хэрэгжүүлээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн 2 алдаа зөрчилд давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өгснөөс 100.0 хувийн хэрэгжилттэй байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	2	11,808.0	2	11,808.0	100.0
Нийт дүн	2	11,808.0	2	11,808.0	100.0

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Шалгагдагч байгууллага дээр ажиллаж хөрөнгийн биет тооллого хийх нөхцөл байдал хязгаарлагдмал байснаас биет тест хэрэгжүүлээгүй.

Дараагийн аудитаар төсвийн жил дамжин хэрэгжиж байгаа сургалтын үйл ажиллагаа, хувьсах зардлын нөхөн хангалтаар авч байгаа тоног төхөөрөмж, бараа материалыг орлогод авсан эсэхийг авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 505,876.1 мянган төгрөгийн 5 алдаа илэрснээс аудитын явцад 505,876.1 мянган төгрөгийн алдааг залруулав.

- Санхүүгийн тайланд төсвийн гүйцэтгэлийн тайланг нэгтгээгүй, 76,361.8 мянган төгрөгөөр төсвийн тохируулгын тайланг бэлтгээгүйг;
- Цалин хөлсний дэлгэрэнгүй бүртгэлээрх цалингийн дүн, хувь хүний орлогын албан татварын татварын цахим системд илгээсэн дүнгээс 295.6 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасныг;
- Төсвийн гүйцэтгэлийн тайланд суралцагчдын тоог тайлагнаагүйг;
- Цалин хөлсний дэлгэрэнгүй бүртгэлээрх цалингийн дүн ерөнхий журналын цалингийн зардлын дүнгээс 236.0 мянган төгрөгөөр зөрүүтэй бүртгэгдсэнийг;
- Сангийн яамны 2023 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн 10/84 дүгээр албан бичгийн дагуу гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжих байгууллагын санхүүгийн тайланг орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн тайлангаас улсын төсвийн ерөнхийлөн захирагчийн тайланд шилжүүлэхтэй холбоотойгоор санхүүгийн байдал, үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайланд тус тус 428,982.7 мянган төгрөгийг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т "Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна" гэж заасныг үндэслэн тус тус залруулсан.

Аудитаар нийт 586.0 мянган төгрөгийн 2 зөрчил илэрснээс, 586.0 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, 1 зөвлөмж өгсөн.

5.1 Төлбөрийн акт

1.Илүү цагийн нэмэгдэл хөлсийг 586.0 мянган төгрөгөөр илүү тооцоолж олгосон байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-т "Аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэл хөтлөлтөд гарсан алдааг алдаа гарсан шалтгаан, залруулах аргыг тодорхой тусгасан баримт, тайланг үндэслэн залруулах бөгөөд зөвшөөрсөн болон залруулга хийсэн албан тушаалтан гарын үсэг зурж баталгаажуулна.", Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын 2021 оны А/192 тоот тушаалын хавсралтын 2.2-т "Илүү цаг, шөнийн цаг, долоо хоногийн амралтын өдөр, нийтээр амрах баярын өдөр ажилласан ажилтны нэмэгдэл хөлсийг тооцох дундаж цалин хөлсийг тодорхойлохдоо тухайн ажилтны сүүлийн 3 сарын цалин хөлсөөр тооцно. Энэ тохиолдолд дундаж цалин хөлсний бүрэлдэхүүнд нэмэгдэл хөлс болон байнгын бус, нэг удаагийн шинжтэй шагнал урамшууллыг оруулахгүй байж болно. Ажил олгогч, ажилтан харилцан тохиролцсоноор нэмэгдэл хөлсийг тооцох дундаж цалин хөлсний бүрэлдэхүүнд нэмэгдэл хөлс болон байнгын бус, нэг удаагийн шинжтэй шагнал урамшууллыг оруулж болно" гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын нийцсэн бөгөөд зохистой байх, иж бүрэн байх гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн А/95 дугаар тушаалын хавсралт "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3.3-т "Цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон" гэж заасныг үндэслэн төлбөрийн акт тогтоосон.

5.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой асуудал

Байгууллагын мөрдөж буй НБББББ нь шинэчлэн батлагдсан УСНББОУС, хууль, тогтоол, тушаал заавруудыг тусгаагүй, байгууллагын удирдлагын тушаал шийдвэрээр батлаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.9-д "нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг" гэж бүртгэлийн суурь, санхүүгийн тайлан гаргахад баримтлах зарчмыг тодорхойлсон журам, заавар, аргачлалыг багтаасан баримт бичгийг", 18 дугаар зүйлийн 18.2-т "Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана", 20 дугаар зүйлийн 20.2.2-

т “Аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулах, батлуулах, хэрэгжилтийг зохион байгуулах” гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын нийцсэн бөгөөд зохистой байх, иж бүрэн байх гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

НБББББ-ийг стандарт, хууль, тогтоомж, тушаал, заавар, дүрэм журамд нийцүүлэн шинэчлэн боловсруулж, баталж мөрдөж ажиллах зөвлөмж өгөв.

2. Анхан шатны баримттай холбоотой асуудал

Цалингийн дэлгэрэнгүй тооцооны цалингийн зөрүү хэсэгт анхан шатны баримтгүйгээр 11,273.0 мянган төгрөгийн залруулга хийгдсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д “анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, 20 дугаар зүйлийн 20.2.4-д “нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах” гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Ажил гүйлгээ хийхдээ анхан шатны баримтыг үндэслэн бүртгэж байх.

Дээрх акт, албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг Төв аймаг дахь төрийн аудитын газарт 2023 оны 6 дугаар сарын 15 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
Санхүүгийн тайланд төсвийн гүйцэтгэлийн тайланг нэгтгээгүй, 76,361.8 мянган төгрөгөөр төсвийн тохируулгын тайланг бэлтгээгүй байна.	1	76,361.8	1	76,361.8	0	-	1	76,361.8				
Цалингийн дэлгэрэнгүй журнал, Хувь хүний орлогын албан татварын тайланг тулган шалгахад татварын цахим системд илгээсэн тайланг 295.6 мянган төгрөгөөр дутуу илгээсэн байна.	1	295.6			1	295.6	1	295.6				
Төсвийн гүйцэтгэлийн тайланд суралцагчдын тоог тайлагнаагүй байна.	1	-	1	-			1	-				
Цалин хөлсний дэлгэрэнгүй бүртгэлийг ерөнхий журналын цалингийн зардалтай тулган шалгахад 236.0 мянган төгрөгөөр зөрүүтэй байна.	1	236.0			1	236.0	1	236.0				
Сангийн яамны 2023 оны 1 дүгээр сарын 5-ны өдрийн 10/84 дүгээр албан бичгийн дагуу Гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжих байгууллагын санхүүгийн тайланг орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн тайлангаас улсын төсвийн ерөнхийлөн захирагчийн тайланд шилжүүлэхтэй холбоотой санхүүгийн байдал, үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайланд тус тус 428,982.7 мянган төгрөгийг залруулаагүй байна.	1	428,982.7	1	428,982.7			1	428,982.7				
Дүн	5	505,876.1	3	505,344.5	2	531.6	5	505,876.1				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Байгууллагын мөрдөж буй НБББББ-нь шинэчлэн батлагдсан УСНББОУС, хууль, тогтоол, тушаал заавруудыг тусгаагүй, байгууллагын удирдлагын тушаал шийдвэрээр батлаагүй байна.	1	-					1	-				
Цалингийн дэлгэрэнгүй тооцооны цалингийн зөрүү хэсэгт анхан шатны баримтгүйгээр 11,273.0 мянган төгрөгийн залруулга хийгдсэн байна. Залруулгын давтан тооцооллыг хийхэд 586.0 мянган төгрөгийг илүү цагийн нэмэгдэл хөлсийг илүү тооцоолж олгосон байна.	1	586.0	1	586.0								
Цалингийн дэлгэрэнгүй тооцооны цалингийн зөрүү хэсэгт анхан шатны баримтгүйгээр 11,273.0 мянган төгрөгийн залруулга хийгдсэн байна	1	11,273.0					1	11,273.0				
Дүн	3	11,859.0	1	586.0			2	11,273.0				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шилэн дансны цахим хуудсыг шалгахад 158 мэдээлэл байршуулахаас 154 мэдээлэл хугацаанд нь байршуулж, 3 мэдээллийг хугацаа хоцроож, 1 мэдээллийг байршуулаагүй, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 12 удаагийн 217,715.7 мянган төгрөгийн орлогын гүйлгээг 271,793.0 мянган төгрөгөөр буюу 54,077.3 мянган төгрөгөөр илүү байршуулж, 17 удаагийн 233,056.1 мянган төгрөгийн орлого, 13 удаагийн 173,685.9 мянган төгрөгийн зарлагын гүйлгээг шилэн дансны цахим хуудсанд байршуулаагүй байна.	1	460,819.3	0	-	1	460,819.3		
Дүн	1	460,819.3	0	-	1	460,819.3		
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дотоод аудитын үйл ажиллагаа нь зөвхөн сургалтын үйл ажиллагаанд чиглэгдсэн, санхүү, шилэн данс, нягтлан бодох бүртгэл, төсвийн тухай, төрийн болон орон нутгийн өмчийн тухай, төрийн хэмнэлтийн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт хийдэггүй, санхүүгийн мэргэжлийн ажилтан дотоод хяналтын ажлын хэсгийн бүрэлдэхүүнд томилогдоогүй, ажилтнууд нь дотоод хяналтын талаар сургалтад хамрагдаагүй, дотоод хяналтын талаар зохих мэдлэг эзэмшээгүй, дотоод хяналтын ажиллах журамгүй байна.	1	-					1	-
Гүйцэтгэлд суурилсан төсвийг цөөн нэр төрлөөр баталснаас шалтгаалж, тээвэр шатахуун, томилолт, сургалт, хөрөнгө бэлтгэх зэрэг зардлуудыг Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар баталсан зардлын ангилал, дансдаар ангилж бүртгээгүй, санхүүгийн тайлангийн үзүүлэлтээр тайлагнаагүй байна.	1	-			1	-		
Хүүхдийн хоол хүнсний материалаас хэмнэгдсэн төсвийн үлдэгдэл 2,086.9 мянган төгрөгийг нөөцөлсөн байна.	1	2,086.9					1	2,086.9
Шалгагдагч байгууллагын худалдан авсан хөрөнгө, материалын дүнг, бэлтгэн нийлүүлэгч байгууллагуудын төлбөрийн цахим системд бүртгэсэн дүнтэй тулгахад 2 иргэн, байгууллагын 1,843.6 мянган төгрөгөөр илүү байна.	1	1,843.6					1	1,843.6
Дүн	4	3,930.5			1	-	3	3,930.5
Нийт дүн	5	464,749.8			2	460,819.3	3	3,930.5